



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тосонцэнгэл сумын хүүхдийн 2-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/159/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улиастай сум
2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Болдбаатар
Утас: 99105506
Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn
Хаан соёмбо аудит ХХК -ы гэрээт аудитор:
Б.Цэрэндэжид
Утас: 99218108
Цахим хаяг: Tserendejid1109@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.07.01 № 216

талай _____ ны № _____ -г

ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН
ХҮҮХДИЙН 2 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
М.БАЯРЖАРГАЛ-Д

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тосонцэнгэл сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Тосонцэнгэл сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тосонцэнгэл сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын тушаал гаргасан боловч комисст танилцуулаагүй, хөрөнгийн тооллого хийгээгүй, аудитын явцад эд хөрөнгийн хэсэгчилсэн тооллого хийж, бодит байдлыг баримтжуулахад 1,749.5 мянган төгрөгийн зөөврийн компьютер дутагдсан, яамны хөрөнгө оруулалт болон хандив тусламжийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, хүнсний үлдэгдлийн 17 нэр төрлийн бүтээгдэхүүнийг тоолоход мах, элсэн чихрийг их хэмжээгээр нөөцөлсөн зэрэг зөрчил байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-д "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана", 73.4-т "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу

D/disk/Албан бичиг/Дүгнэлт

81250375

дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 12 дугаар зүйлийн 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 12.2.2-д "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", 12.2.3-д "эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед", 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэгтэй" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тосонцэнгэл сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь 2024 онд Улсын төсвөөс 589,625.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 34,014.6 мянган төгрөгийн санхүүжилттэй, 96,829.5 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй ажилласан байна. 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 62 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал тутам гаргаж, эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн, биелэлт 94.9 хувьтай үнэлэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Тосонцэнгэл сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар элэгдлээрээ анхны өртөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 11 нэр төрлийн 19,912.5 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж, ашиглалтын хугацааг сунгаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тосонцэнгэл сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь 2024 онд Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 19,982.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнийг данс бүртгэлд тусгасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан****САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Данс	Үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	90,945,992.77	121,837,217.77
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ХӨРӨНГӨ	67,324,090.27	96,829,525.27
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	67,324,090.27	96,829,525.27
3121	Төгрөг	67,324,090.27	96,829,525.27
31211	Төрийн сангийн харилцах	67,324,090.27	96,829,525.27
33	АВЛАГА	200,000.00	-
335	Бусад авлага	200,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	200,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	23,421,902.50	25,007,692.50
351	Түүхий эд материал	378,200.00	2,185,000.00
35110	Тусгай зориулалттай материал	138,200.00	1,945,000.00
35130	Эм боох материал	240,000.00	240,000.00
354	Хангамжийн материал	23,043,702.50	22,822,692.50
35420	Аж ахуйн материал	7,440,762.50	9,186,062.50
35440	Түлш шатах тослох материал	1,800,000.00	450,000.00
35460	Хүнсний материал	5,010,480.00	2,794,170.00
35470	Бусад хангамжийн материал	8,792,460.00	10,392,460.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	516,175,658.76	514,451,432.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	516,175,658.76	514,451,432.84
392	Биет хөрөнгө	508,153,533.76	503,711,432.84
39201	Барилга, байгууламж	530,548,210.00	530,548,210.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(58,837,356.86)	(76,438,596.62)
39205	Машин, тоног төхөөрөмж	46,348,952.00	67,681,582.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(28,733,150.00)	(34,212,593.72)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,249,598.00	15,249,598.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,652,719.38)	(11,926,766.86)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,200,000.00	14,200,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,419,999.96)
39217	Номын фонд	30,000.00	30,000.00
393	Биет бус хөрөнгө	8,022,125.00	10,740,000.00
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00

39302	Хасагдуулга	(1,271,875.00)	(1,650,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,644,000.00	10,740,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	607,121,651.53	636,288,650.61
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0.00	864,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	864,000.00
413	Өглөг	0.00	864,000.00
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	0.00	0.00
4136	Бусад өглөг	-	864,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	864,000.00
51	Засгийн газрын хувь оролцоо	607,121,651.53	635,424,650.61
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГ Сан/ орон нутгийн сан	7,644,000.00	7,644,000.00
51101	Өмч: -Төрийн өмч	7,644,000.00	7,644,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	558,533,551.83	586,836,550.91
51210	Өмнөх үеийн үр дүн	558,533,551.83	558,533,551.83
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	607,121,651.53	635,424,650.61
51220	Тайлант үеийн үр дүн	-	28,302,999.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	40,944,099.70	40,944,099.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	607,121,651.53	636,288,650.61

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Данс	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	522,417,800.00	646,718,730.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,200,000.00	23,078,630.00
120	Нийтлэг татварын бус орлого	14,200,000.00	23,078,630.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	14,200,000.00	23,078,630.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	14,200,000.00	23,078,630.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	508,217,800.00	623,640,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	473,846,200.00	589,625,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	473,846,200.00	589,625,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,371,600.00	34,014,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,371,600.00	34,014,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	459,905,084.41	618,415,730.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	459,905,084.41	618,415,730.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	456,674,397.41	616,223,779.57

2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	304,915,373.00	437,899,273.00
210101	Цалин	216,025,760.00	280,443,495.00
210102	Нэмэгдэл цалин	75,587,910.00	143,974,128.00
210104	Урамшуулал	13,301,703.00	13,481,650.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,934,687.73	54,351,850.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	25,860,162.59	37,010,627.02
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,049,153.73	4,378,813.43
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,724,544.76	2,189,406.98
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	572,800.72	2,154,599.60
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,728,025.93	8,618,402.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,340,913.00	31,172,648.65
210301	Гэрэл цахылгааны зардал	3,951,833.00	6,201,543.65
210302	Түлш, халаалтын зардал	20,584,080.00	22,001,105.00
210303	Цэвэр, бохир усны зардал	2,805,000.00	2,970,000.00
2105	Нормативт зардал	48,053,210.00	51,578,110.00
210502	Хоол	48,053,210.00	51,578,110.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	781,500.00	868,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	781,500.00	868,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,648,713.68	38,353,897.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,593,140.00	9,407,342.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	2,814,773.00	2,793,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,240,800.68	26,152,855.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,230,687.00	2,191,951.35
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		- 2,191,951.35
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		- 2,191,951.35
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт	3,230,687.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,230,687.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)	62,512,715.59	28,302,999.08
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	62,512,715.59	28,302,999.08

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Данс	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	508,217,800.00	623,640,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	508,217,800.00	623,640,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	473,846,200.00	589,625,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	473,846,200.00	589,625,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,371,600.00	34,014,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,371,600.00	34,014,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	441,173,699.73	592,784,665.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	441,173,699.73	592,784,665.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	437,943,012.73	590,592,713.65
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	301,621,306.73	433,236,905.00
210101	Үндсэн цалин	199,818,093.73	278,894,561.00
210102	Нэмэгдэл	88,501,510.00	141,097,745.00
210104	Үр дүнгийн урамшуулал	13,301,703.00	13,244,599.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	43,179,100.00	59,014,200.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	29,361,400.00	40,129,600.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,454,400.00	4,721,100.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,763,400.00	2,360,600.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	691,300.00	2,360,600.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	6,908,600.00	9,442,300.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	29,140,913.00	29,822,648.65
210301	Гэрэл цахилгааны зардал	3,951,833.00	6,201,543.65
210302	Түлш, халаалтын зардал	22,384,080.00	20,651,105.00
210303	Цэвэр, бохир усны зардал	2,805,000.00	2,970,000.00
2105	Нормативт зардал	49,433,080.00	49,361,800.00
210502	Хоол, хүнс	49,433,080.00	49,361,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	781,500.00	868,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	781,500.00	868,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,787,113.00	16,289,160.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,972,340.00	10,288,660.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	2,814,773.00	6,000,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,230,687.00	2,191,951.35
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	2,191,951.35
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,191,951.35
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,230,687.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,230,687.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	67,044,100.27	30,855,435.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,699,900.00	1,350,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,699,900.00	1,350,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,699,900.00	1,350,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,699,900.00	1,350,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,699,900.00)	(1,350,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	64,344,200.27	29,505,435.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,979,890.00	67,324,090.27
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	67,324,090.27	96,829,525.27

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
0 ДАНС	511	51300	51210+51220	
10 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	7644000.00	40944099.70	558533551.83	607121651.53
11 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
12 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7644000.00	40944099.70	558533551.83	607121651.53
13 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
14 Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
15 Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0.00	0.00	0.00	0.00
16 Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
17 Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.00	0.00	28302999.08	28302999.08
18 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	7644000.00	40944099.70	586836550.91	635424650.61

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
------	----------	------------	-----------	-----	------

	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	67,324,090.27	(67,324,090.27)	-
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	656,949,600.00	581,968,903.65	74,980,696.35	88.59
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	656,949,600.00	581,968,903.65	74,980,696.35	88.59
210	Бараа, үйлчилгээний зардал	656,949,600.00	581,968,903.65	74,980,696.35	88.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	520,477,100.00	433,236,905.00	87,240,195.00	83.24
210101	Үндсэн цалин	351,518,700.00	278,894,561.00	72,624,139.00	79.34
210102	Нэмэгдэл	161,799,100.00	141,097,745.00	20,701,355.00	87.21
210104	Урамшуулал	7,159,300.00	13,244,599.00	(6,085,299.00)	185.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,512,800.00	59,014,200.00	2,498,600.00	95.94
210201	Тэтгэврийн даатгал	41,829,600.00	40,129,600.00	1,700,000.00	95.94
210202	Тэтгэмжийн даатгал	4,920,100.00	4,721,100.00	199,000.00	95.96
210203	ҮОМШӨ ний даатгал	2,460,500.00	2,360,600.00	99,900.00	95.94
210204	Ажилгүйдлийн даатгал	2,460,500.00	2,360,600.00	99,900.00	95.94
210205	Эрүүл мэвдийн даатгал	9,842,100.00	9,442,300.00	399,800.00	95.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	29,822,648.65	(29,822,648.65)	-
210301	Гэрэл цахилгаан	-	6,201,543.65	(6,201,543.65)	-
210302	Түлш, халаалт	-	20,651,105.00	(20,651,105.00)	-
210303	Цэвэр, бохир ус	-	2,970,000.00	(2,970,000.00)	-
2105	Нормативт зардал	50,805,900.00	49,361,800.00	1,444,100.00	97.16
210502	Хоол, хүнс	50,805,900.00	49,361,800.00	1,444,100.00	97.16
2106	Эд хогшил худалдан авах	-	2,000,000.00	(2,000,000.00)	-
210604	Урсгал засвар	-	2,000,000.00	(2,000,000.00)	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,044,800.00	868,000.00	1,176,800.00	42.45
210806	Мэдээллийн технологийн зардал	2,044,800.00	868,000.00	1,176,800.00	42.45
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	22,109,000.00	7,665,350.00	14,443,650.00	34.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,102,300.00	1,664,850.00	14,437,450.00	10.34
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,006,700.00	6,000,500.00	6,200.00	99.90
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	589,625,500.00	(589,625,500.00)	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	589,625,500.00	(589,625,500.00)	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	34,014,600.00	(34,014,600.00)	-
132001	Орон нутгийн төсвөөс	-	34,014,600.00	(34,014,600.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	67,324,090.27	(67,324,090.27)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	96,829,525.27	(96,829,525.27)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-

62	АЖИЛЛАГСДЫН ТОО	18.00	18.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	118.00	118.00	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Байхгүй

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тосонцэнгэл сумын хүүхдийн 2-р цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэл:

➤ СӨБ-ыг хүүхдүүдэд олгох

Тосонцэнгэл сумын хүүхдийн 2-р цэцэрлэгийн зорилго: Бид хүүхдийг эрүүл биетэй, саруул ухаантай, сайн хүн болгох үндсийг тавихад оршино.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 62 арга хэмжээ төлөвлөснөөс 49 арга хэмжээ 100 хувь, 12 арга хэмжээ 70 хувь огт хэрэгжээгүй арга хэмжээ байхгүй дүгнэгдэж 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө 94.9 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тосонцэнгэл сумын хүүхдийн 2-р цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Төрийн албаны тухай хууль
2. Төсвийн тухай хууль
3. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
4. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
5. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
6. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
7. СӨБ-н тухай хууль
8. Хөдөлмөрийн тухай хууль
9. Боловсролын ерөнхий хууль
10. Төрийн хэмнэлтийн тухай хууль
11. Шилэн дансны тухай хууль
12. Тендерийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тосонцэнгэл сумын хүүхдийн 2-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд:

Тосонцэнгэл сумын хүүхдийн 2-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 29,167.0 мянган төгрөгөөр буюу 1.04 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	200.0	0.0	0.0
Бараа материал	23,421.9	25,007.6	1,585.7
Үндсэн хөрөнгө	516,175.6	514,451.4	1,724.2
Нийт хөрөнгө	607,121.6	636,288.6	29,167.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	607,121.6	635,424.6	28,303.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	607,121.6	636,288.6	29,167.0

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд:

Авлагын эхний үлдэгдэл 200.0 мянган төгрөгийг тайлант онд барагдуулсан байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 23,421.9 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 65,753.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 64,168.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 25,007.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,585.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 4,446.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдаж авч, хөрөнгө оруулалтаар 19,982.6 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, жилийн эцэст 640,099.3 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 26,152.8 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 658,925.5 мянган төгрөг, нийт зарлагыг 658,925.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, тодотголоор нэмж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 589,625.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 34,014.6 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл улсын төсвийн гүйцэтгэл 592,784.6 мянган төгрөг, зарцуулсан байна.

Жилийн эцэст гүйлгээ хаасны дараа санхүүжилт нэмж олгосон байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
Хөтөлбө рга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Төсвөөс санхүүжих					
71801	Сургуулийн өмнөх боловсрол				
80233	Хүүхэд хамгаалал	811.3	801.7	9.6	98.8%
81605	Эрүүл мэндийг дэмжих	1,844.9	600.0	1,244.9	32.5%
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	50,667.3	49,361.8	1,305.5	97.4%
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,888.5	2,888.5	-	100%
81823	Боловсролын байгууллагын багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	1,659.7	0	1,659.7	100%
81832	Нүүдлийн бүлэгт хамруулах	1,252.4	0	1,252.4	100%
81834	Боловсролын стандарт сургалт	531,174.4	506,466.8	124,707.5	80.2%
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	6,468.4	0	6,468.4	100%
Орон нутгийн төсвөөс санхүүжих					
80109-ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал		34,014.6	31,822.6	2,191.9	93.5%
НИЙТ		630,781.5	592,784.6	137,996.9	93.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 34,014.6 мянган төгрөгийн санхүүжилт авч байна. Гүйцэтгэлээр 31,822.6 мянган төгрөгийг гэрэл цахилгаан, халаалт цэвэр ус, урсгал засварын зардалд тус тус зарцуулж, 2,191.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

Худалдан авалтыг шууд худалдан авалтаар зохион байгуулсан.

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124

дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тосонцэнгэл сумын хүүхдийн 2-р цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Хаан соёмбо аудит” ХХК-ийн гэрээт аудитор Б.Цэрэндэжид гүйцэтгэж Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд анхан шатны хяналт хийж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Тосонцэнгэл сумын хүүхдийн 2-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг 618,415.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 12,368,3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9,894,6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 6 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тосонцэнгэл сумын хүүхдийн 2-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хийсэн тухай бүрд тооцоо бодож, үлдэгдлийг тулган баталгаажуулж байх

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,529.6 мянган төгрөгийн алдаа илэрч, 2,590.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,749.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 189.4 мянган төгрөгийн алдаанд зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

Хандив тусламжаар ирсэн угаалгын автомашиныг бүртгэлд тусгаагүй, мөн Боловсролын яамнаас нийлүүлэгдсэн 662150 төгрөгийн тоос сорогч, 1134880 мянган төгрөгийн угаалгын машиныг бүртгэлд тусгаагүй, хөрөнгийн биет тооллого хийгдээгүй сүүлийн үед нийлүүлэгдэж байгаа зөөврийн компьютерүүдийн үнийг ялгаж мэдэхгүй дутагдал илэрч, хүнсний үлдэгдлийн 17 нэр төрлийн бүтээгдэхүүнийг тоолоход хүнсний материалын дутагдал гараагүй мах, элсэн саахрыг 40-50кг-аар нөөцөлсөн, тогоочийн тайлангаар 13 ш хүнсний материалын 793670 төгрөгийн орлогыг авалгүй зарлага болгосон зөрчил илэрснийг залруулсан.

Шийдвэрлэсэн байдал: Тухайн тайлант хугацаанд алдааг залруулж тайлан балансад тусгуулсан.

5.1 Төлбөрийн акт:

Илэрсэн алдаа: Аудитын явцад эд хөрөнгийн хэсэгчилсэн тооллого хийж, бодит байдлыг баримтжуулахад 1,749,500 төгрөгийн зөөврийн компьютер дутагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 4-т "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн байдал: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.3.2.7-д "төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан", 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтыг үндэслэн тогтоосон төлбөрийн 1,749,500 (нэг сая долоон зуун дөчин есөн мянга таван зуу) төгрөгийг акт тогтоов.

5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж

Илэрсэн алдаа -1: Хүүхдийн хоолыг нормативт зардлаас 189.4 мянган төгрөгөөр илүү зарцуулсан.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" заалт, Засгийн газрын 2019 оны 450, 2024 оны 237 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэн ажиллах

Илэрсэн алдаа -2: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 11 төрлийн 19,912.5 мянган төгрөгийн хөрөнгө элэгдээрээ анхны өртгөө нөхсөн үлдэгдэл өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруу-лаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хандив тусламжаар ирсэн угаалгын автомашиныг бүртгэлд тусгаагүй, мөн Боловсролын яамнаас нийлүүлэгдсэн 662150 төгрөгийн тоос сорогч, 1134880 мянган төгрөгийн угаалгын машиныг бүртгэлд тусгаагүй, хөрөнгийн биет тооллого хийгдээгүй сүүлийн үед нийлүүлэгдэж байгаа зөврийн компьютерүүдийн үнийг ялгаж мэдэхгүй дутгадаг илэрч байна.	1	1,797.0	1	1,797.0			1	1,797.0				
Хүнсний үлдэгдлийн 17 нэр төрлийн бүтээгдэхүүнийг тоолоход хүнсний материалын дутагдал гараагүй мах, этсэн саахрыг 40-50кг-аар нөөцөлсөн, тогочийн тайлангаар 13 ш хүнсний материалын 793670 төгрөгийн орлогыг авалгүй зарлага болгосон зөрчил илэрлээ.	1	793.6	1	793.6			1	793.6				
Дүн	2	2,590.7	2	2,590.7			2	2,590.7				

Мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс													
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн		
Тооллогоор тавилга барилга байгууламж, машин тоног төхөөрөмжийг хэсэгчилэн тооллого хийхэд 1749500 төгрөгийн үнэ бүхий зөврийн компьютер дутагдсан	1	1,749.5	1	1,749.5										
Хүүхдийн хоолыг нормативт зардлаас илүү олгосон	1	189.4					1	189.4						
Анхны өртөө элэгдлээрээ нөхсөн 0 үлдэгдэлтэй байгаа 11 нэр төрлийн 19,912,573.00 төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж ашиглалтын хугацааг сунгах	1													
Дүн	3	1,938.9	1	1,749.5			1	189.4						

